

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны дугаар сарын-
ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9, 57.10, Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг, Прокурорын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, Монгол улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга, дэд даргаас бусад төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ
ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛТНЫ
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ИТГЭЛЦҮҮР

	Албан тушаалын зэрэг зиндаа, адилтгах албан тушаалын зэрэглэл	Албан тушаалын сарын цалингийн итгэлцүүр
1	ТӨ-I	2.68
2	ТӨ-II	2.02
3	ТӨ-III	1.55
4	ТӨ-IV, ТӨ- IYA	1.49
5	ТӨ-V, ТӨ- YA	1.38
6	ТӨ-VI, ТӨ- YIA	1.32
7	Яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын сарын цалингийн хамгийн өндөр шатлал	1.00

--- оОо ---